



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 170

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, түүний харьяа байгууллагын албан ажлын хэрэгцээнд зориулан өөрийн орлогын эх үүсвэрээр 120,000,000.00 (нэг зуун хорин сая) төгрөгт багтаан 2 ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Д.Дамдинцэрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн
170 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР ТҮҮНИЙ ХАРЬЯА
БАЙГУУЛЛАГЫН ХУДАЛДАН АВАХ АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН
ҮЗҮҮЛЭЛТ, ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Тоо шир хэг	Худалдаж авах хөрөнгийн үнийн дээд хязгаар (төгрөг)	
			Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Бага оврын автобус, суудлын тоо 10-12, хөдөлгүүрийн багтаамж 3000 cc дээш	2	60,000,000.00	120,000,000.00
	Нийт дүн			120,000,000.00 (нэг зуун хорин сая)